



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 1 дүгээр сарын 19-ны өдрийн 01/696 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 06 дугаар сарын 05, 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Захиргаа удирдлагын газарт ирүүлж байхыг бүх газар, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар /Э.Эрхэмбаяр/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

151800000098



Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2021 оны 02 дугаар сарын 01-ны
өдрийн 35 дугаар тушаалын хавсралт

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хугацаа	Хариуцах нэгж
1	Авлигын эсрэг тогтоомжийг сурталчлах, гэгээрүүлэх ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарг байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх; 1.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгуулага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах;	-Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх	2021 6 дугаар сарын 05 12 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
		1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;	-Дэмжиж хамтран ажилласан байх -Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх -Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх -Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх	6 дугаар сарын 05 12 дугаар сарын 05 6 дугаар сарын 05 12 дугаар сарын 05	Бүх газар, нэгж ЗУГ, МТХ
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион	2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлэх;	-Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх	6 дугаар сарын 05	ЗУГ

	байгуулах хамруулах	сургалтад			12 дугаар сарын 05	
2.2.	АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх;				6 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
2.3.	Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүн тооцож, тайлагнасан байх;				6 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
3.1.	Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж,				6 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
3.2.	Мөрдөгчийн мэдэгдэл				6 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
3.3.	Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ;				6 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
4.1.	Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;				6 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
4.2.	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас				6 дугаар сарын 05	ЗУГ, ХЭЗХ

		урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	урьдчилан сэргийлэх асуудал тусгагдсан байна.	12 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
5	Авилга, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1.Авлигын эрсдэл ба авилга гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх	-Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх	6 дугаар сарын 05 12 дугаар сарын 05	Бүх газар, нэгж
6	Байгууллагын ажиллагааны нээлттэй сайжруулах Үйл тод, байдлыг сайжруулах	6.1.Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах 6.2.Боловсруулж байгаа хууль УИХ, Засгийн газар, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахми хуудсандаа байршуулсан байх, төсөлд иргэд олон нийт санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байх 6.3. Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй санал солилцсон байх	-хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэхэд анаарсан байх Цахим хуудсанд байршуулсан байна. Цахим хуудсанд байршуулсан байна.	6 дугаар сарын 05 12 дугаар сарын 05 6 дугаар сарын 05 12 дугаар сарын 05	Бүх газар, нэгж Бүх газар, нэгж
		6.4.Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор 6.5.Өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/ 6.6. Дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор 6.7.Жилийн эцсийн санхүүгийн тайлан /5 дугаар сарын 1-ний дотор	Цахим хуудсанд байршуулсан байна. Цахим хуудсанд байршуулсан байна. Цахим хуудсанд байршуулсан байна. Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд Заасан хугацаанд Заасан хугацаанд Заасан хугацаанд	СХОА МТХ СХОА МТХ СХОА МТХ СХОА МТХ

		6.8.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /5 дугаар сарын 1-ний дотор	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.9.Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.10.Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /тагварын орлого, тагварын бус орлогын талаархи мэдээлэл	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.11.Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан /Бүтэн жилээр, Хагас жилээр/	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.12.Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ /Тухай бүр/	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.13.Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр /Тухай бүр/	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	Бүх газар, нэгж
		6.14.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаархи мэдээлэл	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	ГХХАГ СХОА
		6.15.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.16.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.17.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.18.Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайлан	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.19.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүн	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ

		6.20.Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /Бүтэн жилээр/	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ
		6.21.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчдийн нэр, хаяг /Тухай бүр/	Цахим хуудсанд байршуулсан байна.	Заасан хугацаанд	СХОА МТХ

-----000-----